

БНХАУ-ын Бээжин хотод “Нисэхийн цаг уурын үйлчилгээ” сэдэвт олон улсын сургалтанд хамрагдсан товч тайлан

2017.10.03

Нислэгийн цаг уурын төвийн мэдээлэл үйлчилгээний хэлтсийн ахлах синоптик инженер Б.Тэмүлүн БНХАУ-ын Бээжин хотноо 2017 оны 09 сарын 11-нээс 23-ны хооронд Хятадын цаг уурын байгууллагаас зохион байгуулсан “Нисэхийн цаг уурын үйлчилгээ” сэдэвт олон улсын 6 дугаар сургалтанд хамрагдлаа.

Энэхүү олон улсын сургалт зорилго нь олон улсын нисэх буудлын цаг уурын үйлчилгээтэй танилцах, техник технологийн хөгжлийг судлах, цаг агаарын аюултай үзэгдлийг хэрхэн урьдчилан мэдээлэх талаар судлах зорилготой байсан.

Сургалт агуулга:

- Хятадын цаг уурын байгууллага, сургалтын төвтэй товч танилцах
- Доплерийн радар ашиглан цаг агаарын аюултай үзэгдлийг илрүүлэх
- Нислэгийн Цаг Уурын үйлчилгээний талаарх Дэлхийн Цаг Уурын байгууллагын зөвлөмж, зөвөлгөө
- Нислэгт аюултай цаг агаарын үзэгдлийг урьдчилан мэдээлэх систем, техник /Хятад/
Үүнд: мөндөр, догшин хуй салхи, шилжлэг салхи, далайн хар салхи, аянга цахилгаан, аадар бороо, тропикийн циклон гэх мэт/
- Буудал орчмын цаг агаарын богино хугацааны аюултай үзэгдлийг прогнолох
- Цаг агаарын тоон загварын үр дүнг ашиглаж прогноз хийх
- SIGMET
- Аянга цахилгааны богино хугацааны прогноз
- Нисэхийн цаг уурын үйлчилгээ Бээжин, Шанхай, Гуанзао, Хятадын хойд хэсэгт
- FY-4 цаг уурын хиймэл дагуулын систем танилцуулга

Багш нар: Дэлхийн Цаг Уурын байгууллагын албан хаагч, Хятадын шинжлэх ухааны академийн профессор, Хятадын цаг уурын байгууллагын сургалтын төв багш болон Нисэхийн цаг уурын байгууллагын инженерүүд, Хонгконгийн цаг уурын байгууллагын инженер оролцсон.

Сургалтын бүх үйл явц Хятадын цаг уурын байгууллагын сургалтын төвд явагдсан.

Сургалтаар Хятадын цаг уурын байгууллагатай товч танилцсан, мөн нислэгт зориулсан буудал орчмын богино болон урт хугацааны урьдчилсан мэдээ гарахад ашиглаж байгаа зураг мэдээ, тоон прогнозын бүтээгдэхүүний алхамын нарийвчлал өндөртэй, сүлжээ, тоног төхөөрөмж, моделийн шинэ хувилбарууд, нисэх онгоцонд зориулсан цаг уурын мэдээ, цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан прогнолох, FY-4, HIMAWARI-8 хиймэл дагуулын мэдээг ашиглан SIGMET-ийн шинэ платформыг практикт ашиглах болон олон төрлийн лекцүүд орсон.

Уг сургалтанд 21 орны 27 цаг уурчид, олон улсын нисэх буудлуудын синоптик инженерүүд болон цаг уурын байгууллагуудын дарга, менежерүүд хамрагдсан.

Дүгнэлт:

Энэхүү олон улсын сургалтанд сууснаар хөгжиж буй болон бусад улс орнуудаас нислэгийн цаг уурын урьдчилсан мэдээнд болон бусад холбогдох талбарт ажиллаж буй цаг уурчидтай туршлага солилцож, мэдээлэл хуваалцсан. Энэ сургалт нь цаг агаарын нөхцөл байдлыг шинжлэх, цаг агаарын үзэгдэл, параметруудийг урьдчилан таамаглах, цаг агаарын аюултай үзэгдлийг урьдчилан мэдээлэх, цаг агаарын үзэгдлийн аргачлалыг ашиглах, ур чадварыг дээшлүүлэх, ажиглалтын мэдээг/METAR/ ашиглах, буудал орчмын цаг агаарын богино хугацааны аюултай үзэгдлийг прогнозын таарцыг сайжруулахад оролцогчдод тусалсан. Мөн энэхүү курс нь хөгжиж буй орнууд, ялангуяа Азийн орнуудад цаг уурын стандартыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нисэхийн цаг уурын үйлчилгээний сүүлийн үеийн хөгжлийн үе шаттай танилцсан. Нислэгт ашиглаж байгаа өндрийн зураг мэдээ манай хэрэглэж байгаа мэдээтэй адилхан бөгөөд АЗ хэмжээтэй цаасан дээр хэвлэгдсэн. NIMAWARI-8 хиймэл дагуулын мэдээн дээр тулгуурлан SIGMET-ийн шинэ платформ туршилтын хугацаанд явагдаж байгаа. Энийг манай улс ашиглах бүрэн боломжтой. Азийн нислэгийн цаг уурын үйлчилгээний нэгдсэн сайттай болж байгаа тул цаашдаа хамтарч ажиллах боломжтой.

Цаашид хийх ажил:

1. Мэргэжлийн хичээлийн хөтөлбөр боловсруулж МҮХ-ийн синоптик инженерүүдэд сургалт зохион байгуулах
2. Азийн нэгдсэн сайтын үйл ажиллагаанд оролцож, туршлага солилцох
3. SIGMET-ийн шинэ платформын туршилтанд оролцох

Тайлан бичсэн:

НЦУТ-ийн ахлах синоптик инженер

Б.Тэмүлүн

